



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/189

Улаанбаатар хот


Домэйн нэр, цахим шуудангийн
үйлчилгээнд хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны 279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.9.5, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Мэйжикнэт” ХХК-аас ирүүлсэн мэдэгдлийн дагуу тус албаны өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдаж буй веб хостингийн үйлчилгээнд үнэгүй дагалддаг цахим шуудангийн /и-мэйл/ үйлчилгээний төлбөр 2018 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хэрэглэгчийн тоогоор тооцогдох болсонтой холбогдуулан шаардагдах зардал тооцоог хавсралт ёсоор баталсугай.

2. Албаны нийт албан хаагчдын цахим шуудангийн ашиглалтын байдалд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

3. Дээрх үйлчилгээнд шаардагдах 647,350 /зургаан зуун дөчин долоон мянга, гурван зуун тавин/ төгрөгийг Шуудан харилцаа холбооны зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



1110300529

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 07 сарын 01-ний өдрийн
#1299/1007 тушаалын хавсралт



ДОМЭЙН НЭР, И-МЭЙЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Үйлчилгээний нэр	Хугацаа	Төлбөр
1	ubservice.mn домэйн нэрийн үйлчилгээ	1 жил	81,000
2	ubservice.mn 50 ширхэг и-мэйлийн үйлчилгээ	7 сар	507,500
3	НӨАТ /10%/		58,850
4	Нийт		647,350